



ДОРНОГОВЬ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 15/6

Сайншанд сум

“Түншлэл ба хөгжил” бизнес эрхлэгчдийг
дэмжих аймгийн зорилтот хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь заалт, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн бичил, жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг тогтвортой хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Түншлэл ба хөгжил” бизнес эрхлэгчдийг дэмжих аймгийн зорилтот хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Бизнес эрхлэгчдийг дэмжих аймгийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн аж үйлдвэр, хөгжлийн стратеги төлөвлөгөө, аймгийн бодлого хөтөлбөрүүд, аймгийн жил бүрийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан баталж, шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж, хэрэгжилтийг зохион байгуулан бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хорооны ахлагч (Б.Хүдэрболд), аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Батсугир) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Б.ГАНЗОРИГ

442230132

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 102 дугаар сарын 05-ны өдрийн
15/06 дугаар тогтоолын хавсралт



“ТҮНШЛЭЛ БА ХӨГЖИЛ” БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ АЙМГИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийг баталж Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын зорилтуудыг тодорхойлсон.

Энэхүү бодлогын хүрээнд аймаг тус бүрээр газар зүйн нөхцөл байдал, хөгжлийг хязгаарлаж буй асуудал болон цаашдын хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломжийг тодорхойлж, аймгийн хөгжилд дүн шинжилгээ хийх нь чухал ач холбогдолтой гэж үзсэн.

Засгийн газраас Дорноговь аймгийг тээвэр логистик, аялал жуулчлал, хариуцлагатай уул уурхай, аж үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэн үйлдвэр технологийн паркуудыг бүсчлэн байгуулж, түүнийг дагалдуулан хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарыг түлхүү хөгжүүлэх хэтийн төлөв, нөөц боломжтой гэж тодорхойлсон байдаг.

Орон нутгаас дэд бүтэц, боомт, эдийн засгийн чөлөөт бүс, тээвэр логистик, уул уурхай дагасан хүнд үйлдвэрлэл, хөдөө аж ахуйг дагасан хүнс, хөнгөн үйлдвэрлэл, аялал жуулчлалын бүс нутгийн давуу талд тулгуурлан бүс нутгийн интеграцид нэгдэж, үйлдвэрлэлийн гинжин хэлхээ, борлуулалтын нэгдсэн сүлжээ, санхүү хөрөнгө оруулалтын урсгалыг татах, зорилтот стратеги төлөвлөгөө боловсруулж, эдийн засгийн шинэ бүтцийг бий болгох зорилго бүхий “Дорноговь аймгийн аж үйлдвэр, хөгжлийн стратеги төлөвлөгөө”-г аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11/02 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж эхлээд байгаа билээ.

Түүнчлэн “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд “Нээлттэй Дорноговь” чуулганыг зохион байгуулж, олон нийтэд тус аймгийн нутагт хэрэгжиж буй Монгол Улсын эдийн засаг, цаашдын хөгжилд стратегийн ач холбогдол бүхий томоохон төсөл, хөтөлбөрүүд, тэднийг дагасан бизнесийн боломжууд болон Улаанбаатар хот, бусад аймгуудаас шилжин ирэгсдийг дэмжих бодлого шийдвэрүүдийг танилцуулсан.

Улс орон бүрийн эдийн засагт бичил, жижиг, дунд бизнесүүд чухал үүрэгтэй төдийгүй тэднээр дамжуулан нийгэм дэх олон асуудлуудыг шийдвэрлэх боломжтой байдаг тул тэднийг хөгжүүлэх бодлого, дэмжих хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх нь түгээмэл байдаг.

Монгол Улсад 2007 онд “Жижиг, дунд үйлдвэрийн тухай”, 2019 онд “Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай” хуулийг батлан хэрэгжүүлж, дэмжих, чадавхжуулахад чиглэсэн олон арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж ирсэн.

Манай улсад жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг хөгжүүлэх, чадавхжуулах, дэмжих зорилготой олон хөтөлбөр, төслүүдийг Засгийн газар, олон улсын байгууллага, мэргэжлийн холбоодоос хэрэгжүүлж байсан боловч хот хөдөөд хөгжлийн түвшин эрс ялгаатай, нийслэлд хэт төвлөрсөн, албан бус секторын оролцоо их, орон нутагт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ бүрэн төлөвшөөгүй зэрэг алдаа дутагдлууд байсаар байна.

Тиймээс орон нутгийн бизнесийн орчин, бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн өнөөгийн нөхцөл, тулгарч буй бэрхшээл сорилтыг тодорхойлж, тэднийг хөгжүүлэх, чадавхжуулах, дэмжих чиглэлээр хэрэгжсэн бодлого, хөтөлбөрүүдийн үр дүнг харьцуулан судалж, улс, орон нутгийн цаашдын хөгжлийн хэтийн төлөвлөлт, нөөц боломжтой уялдуулан оновчтой тодорхойлох шаардлага үүсэж байгаа юм.


Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын үйлдвэрлэл, технологийн паркуудын нэгдсэн холбоо, "Хөгжлийн шийдэл" ТББ болон бусад сургалт, судалгааны байгууллагуудтай хамтран орон нутгийн бизнесийн орчин, түүний үнэлгээ, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн өнөөгийн нөхцөл, тулгарч буй асуудал, шийдвэрлэх арга зам болон төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, сумдад эдийн засгийн шинэ бүтэц бий болгох системийн талаар судалгааг гүйцэтгэж ирлээ.

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдээс тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодруулахад 67 хувь нь банкны зээлийн өндөр хүү, 25 хувь нь хөнгөлөлттэй зээл авахад банкны шалгуур өндөр, 54 хувь нь мэргэжлийн, тогтвортой ажиллах хүчний дутагдалтай байдаг, 26 хувь нь татварын хэмжээ өндөр гэсэн асуудлуудыг хамгийн чухал шийдвэрлэх асуудлаар нэрлэсэн.

Хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх гарц, шийдлийг тодруулахад судалгаанд оролцогчдын 68 хувь нь бага хүүтэй, урт хугацаатай хөнгөлөлттэй зээл, 57 хувь нь төрийн зүгээс бодлогоор зохицуулах, 42 хувь нь төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, 18 хувь нь хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, 15 хувь нь хуулийн хэрэгжилтийг хангуулах нь хамгийн чухал үүрэгтэй гэж үзсэн байна.


Монгол Улсын Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлд бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг жилийн борлуулалтын орлого, ажилчдын тоог харгалзан 1-10 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч, 10-50 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч, 50-200 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч гэж ангилан үздэг.

Дорноговь аймагт өнөөдрийн байдлаар үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 438 иргэн, 1245 аж ахуйн нэгж байгаагийн 78.7 хувь нь 1-5, 12.0 хувь нь 6-10, 2.4 хувь нь 11-15, 2.27 хувь нь 16-20, 4.63 хувь нь 21-ээс дээш ажилтантай буюу 95.37 хувь нь бичил, 4.63 хувь нь жижиг бизнесийн ангилалд хамаарч байгаа юм.



Тэднийг ажилласан жил, туршлагаар нь харьцуулан үзвэл 6.5 хувь нь 1 жил, 16.7 хувь нь 1-3 жил, 5.5 хувь 3-5 жил, 71.3 хувь 5-аас дээш жил үйл ажиллагаа явуулсан байх ба 38.0 хувь нь хүнсний худалдаа, 20.4 хувь нь үйлдвэрлэл үйлчилгээ, 13.0 хувь нь хоол үйлдвэрлэл, 6.5 хувь нь барилга угсралтын үйл ажиллагаа эрхэлдэг байна.

Манай улсын бизнес эрхлэгчдийг зах зээлд эзлэх хувь хэмжээгээр нь авч үзвэл



хамгийн их буюу ойролцоогоор 40 орчим хувийг манлайлагч, 30 орчим хувийг өрсөлдөгч, 20 орчим хувийг дагалдагч, 10 орчим хувийг сул орон зайг эзлэгчид бүрдүүлдэг байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 18 зочид буудалд 944 хүн, 19 гэр буудалд 420 хүн, 6 жуулчны баазад 314 хүн, 34 зоогийн газарт 1700 хүн, 4 сувиллын газарт 280 хүн нэгэн зэрэг хүлээн авах хүчин чадалтай байгаа нь төвлөрсөн газруудад түлхүү хамаарч байгаа бөгөөд нийт бизнес эрхлэгчдийн 43.5 хувь нь аймгийн төвд, 38.6 хувь нь Замын-Үүд сум, 17.9 хувь нь бусад сумдад байршилтай байдаг.

Тэгвэл бичил болон жижиг, дунд бизнес эрхлэгчид нь ихэвчлэн зах зээлийн сул орон зайд төвлөрөн үйл ажиллагаа явуулдаг ба тэдний гол баримтлах зарчим нь зах зээлд тэргүүлэгч болон өрсөлдөгчөөс бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ ялгарах, хамгийн өндөр үр ашиг, үнэ цэнэ өгөх зах зээлийн сул орон зай буюу тодорхой сегмент дээр төвлөрч байна. Иймээс цаашид зөв төлөвлөлт, системтэйгээр ажиллах нь чухал байна.

Өнөөдөр орон нутгийн нийт бизнес эрхлэгчдийн 95.37 хувь нь бичил, 4.63 хувь нь жижиг бизнесийн ангилалд хамаарч байгаа нь ирээдүйд үүсэх бизнесийн сул орон зай, нийгмийн эрэлт, хэрэгцээ, шаардлагыг хангах боломжгүйд хүрч, зарим нь бизнес эрхлэгчид шахагдан гарах эрсдэл байгааг харуулж байна.

Бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй түгээмэл асуудлуудыг дүгнэн үзэхэд бизнесийн төлөвлөлт, төсөвлөлт, засаглал сул, залгамж халаа, хүний нөөцөө бэлтгээгүй, судалгаагүйгээр өрсөлдөөнд оролцдог нь санхүүгийн дэмжлэг авах боломжийг болон бизнесээ удирдах арга зүйг сулруулж өсөж хөгжих, ангилал ахих боломжийг хязгаарлагч хүчин зүйл болж байна.

Монгол Улсад иргэн, аж ахуйн нэгж шинээр бизнесээ эхлүүлэх, өргөжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн төрийн болон хувийн хэвшлийн зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ цөөнгүй байсаар байна.

Тухайлбал:

- Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн зээл; (ЖДҮ, Хоршоо, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд)
- Арилжааны банкны бизнесийн зээл;
- Олон улсын байгууллагын зээл;
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид;
- Банк бус санхүүгийн байгууллагын зээл;
- Бусад /өсөлтийн төв болгох/

Зах зээл дээр олон санхүүгийн эх үүсвэр, зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэгжсээр байхад төр болон хувийн хэвшлийн байгууллагуудаас бизнесийн салбарт хийсэн судалгаа, шинжилгээгээр бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд хамгийн ихээр тулгамдаж байгаа асуудал нь санхүүгийн эх үүсвэр, зээлийн үйлчилгээ болсоор байгаа нь тэдний чадамж сул, зээлжих зэрэглэл доогуур байгааг илтгэж байна.

Төр нь бизнес эрхлэгчдийг дэмжин хөгжүүлэх замаар нийгмийн суурь асуудлуудыг шийдвэрлэж, цаг үеийн эрэлт, хэрэгцээ, шаардлага, стандартад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, соёлыг нэвтрүүлж эдийн засгийн цар хүрээгээ өргөжүүлэх, шинэ бүтцийг бий болгоход чиглэсэн оновчтой бодлогыг цаг алдалгүй хэрэгжүүлэн зөв чиглүүлэх үүрэгтэй байдаг.

Тиймээс орон нутгийн дэд бүтэц, боомт, эдийн засгийн чөлөөт бүс, тээвэр логистик, уул уурхайд түшиглэсэн хүнд үйлдвэрлэлийн салбарын хурдацтай өсөлтийг дагасан хүн амын шилжилт хөдөлгөөн, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбарт үүсэх өсөн нэмэгдэх эрэлт, хэрэгцээг дотоодоосоо бүрэн хангах чадамжтай бизнес эрхлэгчдийг бэлтгэх, тэднийг сургаж хөгжүүлэх, төлөвшүүлэх, тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа юм.

Мөн түүнчлэн уламжлалт мал аж ахуйг эрчимжсэн мал аж ахуйтай хослуулан эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн бэлтгэж зах зээлийн эргэлтэд оруулах бүтцийг сум бүрт малчид, тариаланчдын хамтын ажиллагаа, хоршин ажиллах чадварт тулгуурлан бий болгож, цаашлаад экспортод чиглэсэн, импортыг орлох нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч “Бизнес эрхлэгч малчин, тариаланч”-ийг бэлтгэх асуудал чухал байна.

Дээрх хэрэгцээ шаардлагын улмаас “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, түүний эхний үе шат болох “Шинэ сэргэлтийн бодлого”-той уялдуулан боловсруулсан “Дорноговь аймгийн аж үйлдвэр, хөгжлийн стратеги төлөвлөгөө”-нд тулгуурлан Дорноговь аймгийн бизнес эрхлэгчдийг дэмжин хөгжүүлэхэд чиглэсэн “Түншлэл ба хөгжил” аймгийн зорилтот хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр.Хөтөлбөрийн хамрах хүрээ

2.1.Дорноговь аймгийн 14 сумын нутагт байнга байрлан үйл ажиллагаа эрхэлдэг ашиг олох зорилго бүхий дотоодын бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүд уг хөтөлбөрт хамрагдана.

2.2.Төрийн бус байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой компани, улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, гадаад улсын хуулийн этгээд, барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ, зуучлалын үйлчилгээ, хууль зүйн зөвлөх үйлчилгээ, худалдаа, үйлчилгээний сүлжээ, хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13.4, 13.5-д заасан үйл ажиллагаа, ашигт малтмал хайх, газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, боловсруулах үйлдвэр, тамхи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, экспорт, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалаа, банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаа, даатгалын үйлчилгээ тус хөтөлбөрт хамаарахгүй.

Гурав. Хөтөлбөрийн зорилго

3.1.Энэхүү хөтөлбөрийн зорилго нь бүс нутгийн онцлог, дэд бүтцийн давуу тал, түүхий эдийн нөөцөд тулгуурлан бичил, жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг тогтвортой хөгжүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээний цар хүрээг өргөжүүлэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, хэмжээ, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, импортыг орлох, экспортод чиглэсэн нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгоход чиглэсэн санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд оршино.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт

4.1. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

4.1.1.Орон нутгийн бичил, жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийг тогтвортой хөгжүүлэх;

4.1.2.Үйлдвэрлэл, үйлчилгээний цар хүрээг өргөжүүлэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, хэмжээ, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;

4.1.3.Импортыг орлох, экспортод чиглэсэн нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгох;

4.1.4.Санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

Тав.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

5.1.1.Орон нутгийн бичил, жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийг тогтвортой хөгжүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.1.1.1.Зах зээлийн эрэлт, хэрэгцээ, шаардлагыг үндэслэн салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, “иргэнээс-бичилд, бичлээс-жижигт, жижигээс-дундруу” ангилалд шилжин хөгжихөд сургах, давтан сургах зэрэг нөлөөллийн ажлууд хийх;

5.1.1.2.Сумдад бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх “Сургагч багш, зөвлөх” нарыг бэлтгэн (аутсорсинг, консалтинг г.м) ажиллах нөхцөлөөр ханган сургалт, нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх;

5.1.1.3.Техник технологийн дэвшлийг ашиглах, санхүү хөрөнгө оруулалтын таатай боломжийг хүртэх, зах зээлээ өргөжүүлэх, бизнесийн шинэ боломжуудыг олж харахад судалгаа, мэдээллийн хүртээмжтэй, хэрэгцээтэй байх нөхцөлийг бүрдүүлэх;

5.1.1.4.Бизнесийн засаглал, удирдах арга барил, бизнесийн тогтвортой үйл ажиллагааны төлөвлөлт, залгамж халааны бодлого, хүний нөөцийг бэлтгэх /Политехникийн коллежийн сургалтыг уялдуулан/ мэдлэг, чадвар олгох;

5.1.1.5.Инноваци, технологийн шинэчлэл хийхээр төлөвлөж буй ААН-д мэргэжлийн экспертүүдээс бүрдсэн бизнесийн зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх;

5.1.2.Үйлдвэрлэл, үйлчилгээний цар хүрээг өргөжүүлэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, хэмжээ, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.1.2.1.Уул уурхайн болон томоохон төсөл хөтөлбөрийн бэлтгэн нийлүүлэлтэд бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийг татан оролцуулах зохицуулалтыг бий болгох;

5.1.2.2.Бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлэх бодлого хэрэгжүүлэх;

5.1.2.3.Бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний бусдаас ялгарах онцлог, давуу талыг дэмжин хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх;

5.1.2.4.Бизнесээ байгаль орчин, нийгэмд ээлтэй, ил тод засаглал бүхий, стандартын шаардлага хангасан, өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах ажлыг эрчимжүүлэн, зохих бодлогоор дэмжих;

5.1.2.5.Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих;

5.1.3.Импортыг орлох, экспортод чиглэсэн нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгох зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.1.3.1.Бараа, бүтээгдэхүүний шууд борлуулалтын /Дорноговьд үйлдвэрлэв төв гэх мэт/ цэгийн тоог нэмэгдүүлэх;

5.1.3.2.Орон нутагт түүхий эд бэлтгэлийн тогтолцоог үйлдвэрлэл борлуулалтын нэгдсэн систем бүхий хоршооны бүтцэд тулгуурлан бий болгох;

5.1.3.3.Хорших, хамтрах үйл явцыг дэмжих замаар үйлдвэрлэл, борлуулалтын гинжин холбоо, нэмүү өртгийн сүлжээ, кластерийн зохион байгуулалтыг бий болгох;

5.1.3.4.Үйлдвэрлэгчид, үйлчилгээ эрхлэгчдийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн худалдаа, мэдээллийн нэгдсэн цахим платформ, борлуулалтын нэгдсэн сувагтай болгох;

5.1.3.5.Шинжлэх ухааны хүрээлэн, их, дээд сургуулиудын эрдэмтдийн бүтээсэн инноваци, шинэ технологи, шинэ бүтээгдэхүүнийг жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхийг бодлогоор дэмжиж, холбогдох төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

5.1.4.Санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.1.4.1.Монгол Улсын Засгийн газрын тусгай сан болох "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан"-д орон нутгийн төсвөөс санхүүжилт хуваарилан төвлөрүүлэх замаар сангийн хөрөнгийг орон нутгийн бизнес эрхлэгчдэд журмын дагуу бүрэн олгох арга хэмжээг зохион байгуулах;

5.1.4.2.Сумдад эдийн засгийн шинэ бүтэц бий болгохуйц, аймгийн Аж үйлдвэр хөгжлийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан загвар /модель/ төслүүдийг санхүүжүүлэн хэрэгжүүлэх (хоршоо, нөхөрлөлд тулгууран кластерын системээр ажиллах);

5.1.4.3.Кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулах жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг тухайн орон нутаг дахь түүхий эдийн болон ажиллах хүчний нөөц, чадавх бусад онцлогоос хамааран дэмжих;

5.1.4.4.Техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

- 5.1.4.5. Гадаад, дотоод зах зээлд бүтээгдэхүүнээ гаргахад дэмжлэг үзүүлэх.
- 5.1.4.6. Бизнес эрхлэгчдийг дэмжих, бойжуулах ажлыг аймгийн бизнесийн тэргүүлэх чиглэлээр ажиллаж буй залуучууд, эмэгтэйчүүд гэх мэт зорилтот бүлгийг дэмжих, тэднийг бизнес эрхлэхэд таатай дэд бүтцийн орчин бүрдүүлэхэд чиглүүлэх
- 5.1.4.7. Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

Зургаа. Хөтөлбөрийн үр дүн

- 6.1. Хөтөлбөрт хамрагдсан аж ахуйн нэгжийн бие даасан байдал, өрсөлдөх чадвар сайжирч, "иргэнээс-бичилд, бичлээс-жигигт, жигигээс-дундруу" ангилал ахисан бизнес эрхлэгчдийн тоо өссөн байна.
- 6.2. Орон нутагт зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн баг, сургагч багш нар бэлтгэгдсэн байна.
- 6.3. Бизнес эрхлэгчид шаардлагатай мэдээ, мэдээллийг цаг алдахгүй хүртээмжтэй авах нөхцөл бүрдсэн байна.
- 6.4. Уул уурхайн болон томоохон төсөл хөтөлбөрийн бэлтгэн нийлүүлэлтэд бичил, жигиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийг татан оролцуулах зохицуулалт бий болсон байна.
- 6.5. Дотоодын үйлдвэрээс худалдан авах төрийн байгууллагын худалдан авалт нэмэгдсэн байна.
- 6.6. Байгаль орчин, нийгэмд ээлтэй, ил тод засаглал бүхий, стандартын шаардлага хангасан, өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний тоо өссөн байна.
- 6.7. Орон нутагт үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний шууд борлуулалтын цэг байгуулагдсан байна.
- 6.8. Орон нутагт түүхий эд бэлтгэлийн тогтолцоог үйлдвэрлэл борлуулалтын нэгдсэн систем бүхий хоршооны бүтцэд тулгуурлан бий болгосон байна.
- 6.9. Сумдад эдийн засгийн шинэ бүтэц бий болгохуйц, аймгийн Аж үйлдвэр хөгжлийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан загвар /модель/ төсөл (хоршоо, нөхөрлөлд тулгуурлан кластерын системээр ажиллах)-ийг санхүүжүүлэн хэрэгжүүлсэн байна.
- 6.10. Орон нутгийн дэд бүтэц, боомт, эдийн засгийн чөлөөт бүс, тээвэр логистик, уул уурхайд түшиглэсэн хүнд үйлдвэрлэлийн салбарын хурдацтай өсөлтийг дагасан хүн амын шилжилт хөдөлгөөн, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбарт үүсэх өсөн нэмэгдэх эрэлт, хэрэгцээг дотоодоосоо хангахад чиглэгдсэн бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд холбогдох журам, хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Долоо. Хөтөлбөрийн хугацаа, шалгуур үзүүлэлт

- 7.1. Хөтөлбөрийг 4 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ.
- 7.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргаас холбогдох стратеги, бодлого хөтөлбөр, төлөвлөлт, төсөвтэй уялдуулан шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, суурь түвшин, хүрэх түвшин, үр дүн бүрээр нарийвчлан жил бүр төлөвлөж хэрэгжүүлнэ.


Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

- 8.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах санхүүгийн эх үүсвэрийг ашиглана:
- 8.1.1. Улсын болон орон нутгийн төсөв;
- 8.1.2. Олон улсын байгууллага, гадаадын зээл, тусламж;
- 8.1.3. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;

8.1.4.Засгийн газрын тусгай сангийн хөрөнгө;

8.1.5.Хувийн хэвшил болон бусад эх үүсвэр;

**Ес.Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх
хяналт, шинжилгээ үнэлгээ**



9.1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын салбар хариуцсан нэгж жил бүр хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулна.

9.2.Аймгийн Засаг дарга нь 9.1-д заасан хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг жил бүр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

9.3.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

---o0o---